



**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр

№ 01

Улаанбаатар хот

**Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх
Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, 62.1.14, 96.5 дахь заалт, Монголын цахилгаан холбоо ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.7 дахь заалт, 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг тус тус зөвшөөрч баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Ж.БААСАНДОРЖ



**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр

№ 02

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлж, сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, 77 дугаар зүйлийн 77.4 дэх хэсэг, Монголын цахилгаан холбоо ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.6, 7.10, 7.16, 7.18 дахь заалт, 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд нэр дэвшигчдээс кумулятив аргаар хамгийн олон санал авсан Х.Баянбай, С.Цолмон, Н.Туул нарыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр, Ц.Баяр-Эрдэнэ, А.Молор, Д.Нарангэрэл, Б.Билэгдэмбэрэл, Б.Төрбат, С.Ганзориг нарыг Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдрөөс тус тус сонгосугай.

2. Ц.Норовжамцыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүний үүрэгт ажлаас 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдрөөр тасалбар болгон чөлөөлж, бүрэн эрхийг нь дуусгавар болгосугай.

3. Компанийн үйл ажиллагааг үр ашигтай удирдан зохион байгуулж, холбогдох хууль, дүрэм, журмын дагуу ажиллахыг сонгогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ж.БААСАНДОРЖ



**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр

№ 03

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны зардлын төсвийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, Монголын цахилгаан холбоо ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.6 дахь заалт, 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны зардлын төсвийг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавьж, зардал хэтрүүлэхгүй, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалинг түүний ажлын үр дүнг харгалзан олгож байхыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ж.БААСАНДОРЖ



ТУЗ-ИЙН 2025 ОНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ

(Нэгж: төгрөг)

№	Зардлын төрөл	Тоо	Нэгж зардал	Давтамж	Нийт дүн
1. Цалингийн зардал					
1	ТУЗ-ийн дарга	1	1,400,000	12	16,800,000
2	ТУЗ-ийн хараат бус гишүүн	3	1,320,000	12	47,520,000
3	ТУЗ-ийн ердийн гишүүний цалин	5	1,200,000	12	72,000,000
4	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	1	1,200,000	12	14,400,000
	Цалингийн зардлын дүн				150,720,000
5	Нийгмийн даатгалын шимтгэл				20,045,760
	Дэд дүн				170,765,760
2. Бичиг хэрэг, хурал, холбоо, тээврийн зардал					
1	Бичиг хэрэг, хэвлэмэл материал, цай, кофены зардал	1	180,000	12	2,160,000
2	Хурал зохион байгуулах байрны түрээс	1	200,000	2	400,000
3	ТУЗ-ийн нарийн бичгийн даргын холбоо, тээврийн зардал	1	180,000	12	2,160,000
4	Бусад зардал	1	100,000	5	500,000
	Дэд дүн				5,220,000
3. Сургалт, компанийн салбар, нэгжүүдийн үйл ажиллагаатай танилцах зардал					
1	Сургалт, семинарын зардал				8,500,000
2	Томилолтын зардал				10,000,000
	Дэд дүн				18,500,000
	НИЙТ ДҮН				194,485,760

Тайлбар: Төсөв 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас дараа (2026) оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэл хугацаанд хамаарна.



**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр

№ 04

Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөл болон түүний дэргэдэх хороодын ажлын
гүйцэтгэлийг үнэлэх үнэлгээний аргачлал батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь заалт, 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл болон түүний дэргэдэх хороодын ажлын гүйцэтгэлийг үнэлэх аргачлалыг хавсралтаар баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Ж.БААСАНДОРЖ

Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2025 оны
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын
№ 04 тогтоолын Хавсралт



**“МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО” ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ БОЛОН ТҮҮНИЙ ДЭРГЭДЭХ ХОРООДЫГ ҮНЭЛЭХ
АРГАЧЛАЛ**

**Улаанбаатар хот
2025 он**

ҮНДЭСЛЭЛ

Компанийн засаглал нь компанийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгож, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, компанийн тогтвортой хөгжлийг дэмжихэд чиглэсэн зохицуулалтын үндсэн хүрээ юм. Үүний нэг чухал бүрэлдэхүүн хэсэг нь ТУЗ болон түүний дэргэдэх хороодын үйл ажиллагааг бодитой үнэлэх, үр нөлөөг нь сайжруулах явдал юм.

Компанийн тухай хуулийн 81.5.4-т, нэр дэвшүүлэх хороо нь "Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын гишүүдийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх" үүрэгтэй бөгөөд энэхүү зохицуулалт нь компанийн удирдлагын хяналтыг сайжруулах, ТУЗ-ийн хариуцлагыг нэмэгдүүлэх, гүйцэтгэлийн үнэлгээг илүү үр дүнтэй болгох зорилготой юм.

Компанийн засаглалын кодексийн 1.3-ийн Тайлбар 1-д зааснаар, компани нь ТУЗ, түүний дэргэдэх хороод, ТУЗ-ийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийн ажлын гүйцэтгэлийг жилд нэг удаа тогтмол хугацаанд үнэлж, тайлагнах үүрэгтэй. Энэ нь компанийн засаглалын тасралтгүй сайжруулалт, үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн чухал зохицуулалт юм. Түүнчлэн, 1.3-ийн Тайлбар 3-т зааснаар, ТУЗ-ийн даргын ажлын гүйцэтгэлийн үнэлгээг хараат бус гишүүн хариуцаж, бусад гишүүдийн саналыг авсны үндсэн дээр дүгнэх шаардлагатай гэж заасан. Энэ нь үнэлгээний хараат бус байдлыг хангаж, бодит үр дүн гаргахад чиглэсэн зохицуулалт болж байна.

Олон улсын компанийн засаглалын зарчмын 3.1.3-д заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлаар ТУЗ-ийн гишүүдийг үнэлэх системийг хэлэлцэн шийдвэрлэх зохицуулалттай байхыг онцолсон. Мөн 4.6.2-т, цалин урамшууллын хороо нь ТУЗ-ийг үнэлж дүгнэх системтэй байх шаардлагатайг зааж өгсөн бөгөөд ТУЗ-ийн гүйцэтгэлийг бодитой хэмжиж, хариуцлагыг өндөржүүлэх, компанийн урт хугацааны тогтвортой байдлыг хангахад чиглэсэн байна.

Дээрх хууль эрх зүйн зохицуулалт болон ОУ-ын компанийн засаглалын шилдэг туршлагад үндэслэсэн энэхүү аргачлалыг "Монголын Цахилгаан Холбоо" ХК-ийн ТУЗ болон түүний дэргэдэх Аудитын хороо, Цалин урамшууллын хороо, Нэр дэвшүүлэх хороо тус бүрийн үйл ажиллагааны онцлог, чиг үүрэгт нийцүүлэн үнэлгээний аргачлал боловсруулав.

1. ЗОРИЛГО

ТУЗ болон түүний дэргэдэх хороодын үнэлгээний гол зорилго нь компанийн засаглалын үр нөлөөг нэмэгдүүлэх, удирдлагын тогтолцооны хяналт, хариуцлагыг сайжруулах, шийдвэр гаргалтын чанар, үр ашигтай байдлыг дээшлүүлэхэд чиглэнэ. Мөн компанийн стратегийн зорилтыг оновчтой тодорхойлж, эрсдэлийн удирдлагын тогтолцоог хөгжүүлэх, ил тод, хариуцлагатай засаглалыг төлөвшүүлэх, хөрөнгө оруулагчид болон хувьцаа эзэмшигчдийн итгэлийг нэмэгдүүлэхэд энэхүү үнэлгээний үйл явц чухал үүрэг гүйцэтгэнэ.

2. АЧ ХОЛБОГДОЛ

Энэхүү аргачлалыг хэрэгжүүлснээр "МЦХ" ХК-ийн удирдлагын тогтолцоо илүү үр дүнтэй болж, хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид болон бусад оролцогч талуудын эрх ашиг хамгаалахын зэрэгцээ үнэлгээ нь компанийн стратегийн шийдвэр гаргалтыг оновчтой болгох, эрсдэлийг удирдах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, зах зээлд өрсөлдөх чадварыг нь дээшлүүлэх зэрэг дараах ач холбогдолтой байна. Үүнд:

Компанийн засаглалыг сайжруулах: Энэхүү үнэлгээ нь компанийн удирдлагын хяналтын механизм хэр үр дүнтэй ажиллаж байгааг тодорхойлж, сайжруулах боломжийг бүрдүүлнэ. Үнэлгээний дүнд үндэслэн ТУЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүн, хараат бус байдал, шийдвэр гаргах үйл явцад шаардлагатай өөрчлөлт, шинэчлэл хийх боломжтой болно.

Хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэх: Компанийн удирдлагын тогтолцоо хэр сайн ажиллаж байгааг тогтмол үнэлж, тайлагнах нь хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчдийн итгэлийг нэмэгдүүлнэ. Ил тод, хариуцлагатай засаглалтай компани нь санхүүгийн зах зээл дээр илүү тогтвортой, үнэ цэнтэй байж, хөрөнгө оруулалтын орчин сайжирна.

Шийдвэр гаргалтын чанарыг сайжруулах: ТУЗ-ийн гишүүдийн ажлын гүйцэтгэлийг бодитой үнэлснээр шийдвэр гаргалтын чанар сайжирч, компанийн стратегийн зорилтууд илүү үр дүнтэй хэрэгжих боломжтой. Ялангуяа хороодын чиг үүрэг, хяналтын үйл ажиллагааны үр нөлөөг үнэлснээр компанийн эрсдэлийг удирдах, санхүүгийн тогтвортой байдлыг хангах нөхцөл бүрдэнэ.

Эрсдэлийн удирдлагыг сайжруулах: Компанийн эрсдэлийн удирдлагын үр ашгийг нэмэгдүүлж, санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэлүүдийг урьдчилан илрүүлэх, удирдахад чухал үүрэг гүйцэтгэнэ. Хөрөнгө оруулагчид болон бусад оролцогч талууд эрсдэлийн удирдлага сайтай компанид илүү итгэлтэй ханддаг.

Ил тод байдал, хариуцлагыг нэмэгдүүлэх: Тогтмол үнэлгээ хийж, үр дүнг тайлагнах нь компанийн ил тод байдлыг нэмэгдүүлж, удирдлагын хариуцлагыг өндөржүүлнэ. Энэ нь компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хамгаалах, шударга засаглалыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой.

Олон улсын шилдэг туршлагыг нэвтрүүлэх: Олон улсын компанийн засаглалын зарчимд нийцсэн үнэлгээний аргачлалыг хэрэгжүүлснээр компани нь олон улсын зах зээлд өрсөлдөх чадвараа нэмэгдүүлж, хөрөнгө оруулалт татах боломжтой болно. Үнэлгээний тогтолцоо сайжирснаар компанийн удирдлага, хяналтын тогтолцоог олон улсын стандартын дагуу хөгжүүлэх нөхцөл бүрдэнэ.

3. ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

3.1. Үнэлгээний бүтэц

Үнэлгээний аргачлал нь компанийн засаглалын түвшинг олон улсын стандарт, шилдэг туршлагатай хэрхэн нийцэж байгааг тодорхойлоход чиглэсэн. Үнэлгээг гаргахдаа тодорхой шалгуур, жинлэсэн онооны систем ашигласан. ТУЗ-ийг үнэлэх аргачлал нь шалгуур бүр 10 оноотой байх ба нийт 100 онооны үнэлгээний системд суурилсан. Шалгуур бүрт 5 дэд шалгуур хамаарах бөгөөд тэдгээрийн хэрэгжилтийн түвшнийг "бүрэн хэрэгжсэн" (2 оноо), "хэсэгчлэн хэрэгжсэн" (1 оноо), "огт хэрэгжээгүй" (0 оноо) гэсэн ангиллаар үнэлсэн. Дэд шалгуурын онооны нийлбэрийг тухайн шалгуурын жингээр үржүүлж, эцсийн үнэлгээг гаргасан. Харин ТУЗ-ийн дэргэдэх хороодын хувьд Аудитын хорооны үнэлгээ нь нийт 8 үндсэн шалгуур бүхий 25 үзүүлэлтээс, Нэр дэвшүүлэх болон Цалин урамшууллын хороо нь 7 үндсэн шалгуур бүхий 20 үзүүлэлтээс бүрдэнэ. Тухайн үзүүлэлт тус бүрийг хэрэгжилтийн түвшинг харгалзан "бүрэн хэрэгжсэн" (3 оноо), "ихэвчлэн хэрэгжсэн" (2 оноо), "бараг хэрэгжээгүй" (1 оноо), "огт хэрэгжээгүй" (0 оноо) гэсэн үнэлгээний ангиллаар үнэлнэ.

3.2. Үнэлгээний түвшин

ТУЗ-ийн үнэлгээг 100 онооны системд суурилж, дараах 5 түвшингээр ангилна. Үүнд:

Түвшин	Үнэлгээний тайлбар	ТУЗ-ийн онцлог шинж чанар	Ашиглах арга
90%-100% (Маш сайн)	Үндсэн шаардлагуудыг бүрэн хангаж, хараат бус байдал, хяналтын механизм өндөр түвшинд байна.	- ТУЗ-ийн хараат бус байдал сайн хангагдсан. - Шийдвэр гаргах үйл явц үр дүнтэй, тогтмол мониторинг хийдэг. - Эрсдэлийн удирдлага, аудитын хяналт сайн хэрэгждэг.	Тогтолцоог улам төгөлдөржүүлэх, илүү нарийвчилсан бодлого боловсруулах.
80%-89% (Сайн)	ТУЗ-ийн үйл ажиллагаа сайн боловч тодорхой сайжруулалт шаардлагатай.	- Хяналтын систем ажилладаг боловч зарим чиглэлээр сайжруулах шаардлагатай. - Хараат бус байдлын баталгаа хангалттай боловч зарим гишүүдийн оролцоо сул. - ТУЗ-ийн шийдвэр гаргалт үр дүнтэй боловч ил тод байдлыг нэмэгдүүлэх.	Тодорхой доголдлыг арилгах, хяналтын механизмуудыг илүү хүчтэй болгох.
70%-79% (Дунд)	ТУЗ үндсэн үүргээ гүйцэтгэж байгаа ч үр нөлөө дутмаг.	- ТУЗ-ийн хараат бус байдал хангалттай биш, гишүүдийн оролцоо тогтмол биш. - Эрсдэлийн удирдлага, аудитын хяналт сул. - Шийдвэр гаргалт саатах, стратегийн удирдлагын нөлөөлөл хангалтгүй.	Бодлогын шинэчлэл хийх, хяналтын системийг бэхжүүлэх шаардлагатай.
50%-69% (Хангалтгүй)	ТУЗ-ийн хяналт, хараат бус байдал хангалтгүй, ил тод байдал сул.	- ТУЗ бодлогын хэрэгжилтийг бүрэн хянаж чаддаггүй. - Санхүүгийн хяналт, аудитын тогтолцоо сул. - Шийдвэр гаргалт удаашралтай, хариуцлагын тогтолцоо бүрхэг.	ТУЗ-ийн бүтэц, хараат бус байдлыг эргэн харах, хяналтын механизмд суурь өөрчлөлт хийх.
0%-49% (Маш муу)	ТУЗ үндсэн үүргээ биелүүлж чадахгүй, байгууллагын засаглалын эрсдэл өндөр.	- ТУЗ-ийн хараат бус байдал алдагдсан. - Санхүүгийн тайлагнал, хяналт, аудитын механизм хангалтгүй. - Бодлого, шийдвэр гаргалтын тогтолцоо үр дүнгүй.	ТУЗ-ийн үйл ажиллагаанд суурь өөрчлөлт хийх, хараат бус гишүүдийг нэмэх, ил тод байдлыг сайжруулах.

Хороодын үнэлгээг 100 онооны системд суурилж, дараах 5 түвшингээр ангилна. Үүнд:

Түвшин	Үнэлгээний тайлбар	Хорооны онцлог шинж	Ашиглах арга
90%-100% (Маш сайн)	Хороо бүрэн хүчин чадлаараа, үр нөлөөтэй ажиллаж байна. Шийдвэрүүд нь стратегид бодит хувь нэмэр оруулдаг.	- Хорооны гишүүдийн оролцоо өндөр - Шийдвэрийн хэрэгжилт дээд түвшинд - Бүтээлч, үр ашигтай хяналтын тогтолцоо	- Шийдвэрийн хэрэгжилт болон үр дүнг хянах - Тайлан, хяналтын чанарыг нарийвчлан шалгах

80%-89% (Сайн)	Үндсэн чиг үүргээ сайн гүйцэтгэж байгаа, гэхдээ зарим сайжруулалт шаардлагатай. Шийдвэрийн хэрэгжилт сайн боловч бүх асуудлыг бүрэн хамарч чадахгүй байна.	- Гишүүдийн оролцоо сайн - Шийдвэрүүд хэрэгжиж байна, гэхдээ зарим нь удаашралтай	- Оролцогчдын санал хүсэлтийг авч сайжруулалт хийх - Эрсдэлийн удирдлагыг нэмэгдүүлэх
70%-79% (Дунд)	Үйл ажиллагаа тогтмол боловч шийдвэрийн хэрэгжилт сул, үр нөлөө бага байна. Зарим шийдвэр хоцорч хэрэгжиж, хяналтын тогтолцоо дутмаг.	- Шийдвэрийн хэрэгжилт удаашралтай - Хяналтын тогтолцоо хангалтгүй	- Үр дүнгийн дүн шинжилгээ хийх - Шийдвэрийн хэрэгжилтийг сайжруулах
50%-69% (Хангалтгүй)	Үндсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж чадахгүй байгаа. Хурлын оролцоо бага, шийдвэр гаргалт сул байна.	- Шийдвэрийн хэрэгжилт удаашралтай, эсвэл хэрэгжээгүй - Хорооны үйл ажиллагаа дутуу	- Үйл ажиллагааны сайжруулалтыг шуурхай хийх - Шийдвэрийн хэрэгжилтэд анхаарлаа хандуулах
0%-49% (Маш муу)	Хорооны үйл ажиллагаа доголдолтой, үр нөлөөгүй. Шийдвэрүүд хэрэгжихгүй, хуралдаан бараг хийгддэггүй.	- Хорооны үйл ажиллагаа бүрэн доголдсон - Шийдвэрүүд хэрэгжихгүй	- Хорооны бүтэц, үйл ажиллагааг шинэчлэх - Үйл ажиллагааны хяналтыг бүрэн шинэчлэх

Жич: Энд тухайн хороодын хэлэлцсэн хурал, шийдвэрийн хэрэгжилтийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг цуглуулах, хэрэгжүүлсэн шийдвэрүүдийг үнэлж, үр дүнг нь тооцоолох, бүх гишүүдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор санал асуулга эсвэл ярилцлага явуулах, оролцогчдын шийдвэрийн хэрэгжилт болон түүний гүйцэтгэлийг судлах.

3.3. Үнэлгээний асуулт

Хүснэгт 1. ТУЗ-ийн үнэлгээний асуулт

	ХАРИУЛТ	ОНОО	ЖИН	ҮНЭЛГЭЭ
1. ТУЗ-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	10 оноо	10	5	10%
1.1. ТУЗ-ийн гишүүдийн тоо Компанийн тухай хуульд заасан шаардлагыг хангаж байгаа эсэх				
1.2. ТУЗ-ийн гишүүдийн дунд хараат бус гишүүдийн хувь зохих хэмжээнд байгаа эсэх				
1.3. ТУЗ-ийн дарга болон гүйцэтгэх удирдлагын үүрэг, хариуцлага тусгаарлагдсан эсэх				
1.4. ТУЗ-ийн дэргэдэх аудит, цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хороод байгуулагдсан эсэх				
1.5. ТУЗ-ийн гишүүдийн сонгон шалгаруулалт, томилгоо нь ил тод, шударга явагддаг эсэх				
2. ТУЗ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ	10 оноо	10	5	10%
2.1. ТУЗ-ийн хуралдааны давтамж Компанийн тухай хуульд заасан шаардлагыг хангаж байгаа эсэх				
2.2. ТУЗ-ийн хуралдааны ирц хангалттай байгаа эсэх				
2.3. ТУЗ-ийн хуралдааны тэмдэглэл зохих ёсоор хөтлөгдөж, хадгалагддаг эсэх				

2.4. ТУЗ-ийн шийдвэрүүд цаг тухайд нь гарч, хэрэгжиж байгаа эсэх				
2.5. ТУЗ-ийн гишүүдийн оролцоо, хувь нэмэр хангалттай байгаа эсэх				
3. СТРАТЕГИ УДИРДЛАГА	10 оноо	10	5	10%
3.1. ТУЗ нь компанийн урт хугацааны стратегийг тодорхойлсон эсэх				
3.2. Стратегийн зорилтуудыг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлагдсан эсэх				
3.3. ТУЗ нь стратегийн хэрэгжилтэд хяналт тавьдаг эсэх				
3.4. Стратегийн эрсдэлүүдийг тодорхойлж, удирддаг эсэх				
3.5. ТУЗ нь компанийн үнэт зүйлс, ёс зүйн зарчмуудыг тодорхойлсон эсэх				
4. САНХҮҮГИЙН ХЯНАЛТ БА АУДИТ	10 оноо	10	5	10%
4.1. ТУЗ нь компанийн санхүүгийн тайланг тогтмол хянадаг эсэх				
4.2. Дотоод аудитын алба байгуулагдсан эсэх				
4.3. Гадаад аудитын байгууллагыг хараат бус байдлаар сонгон шалгаруулдаг эсэх				
4.4. Аудитын дүгнэлт, зөвлөмжийг ТУЗ хэлэлцэж, хэрэгжүүлдэг эсэх				
4.5. Санхүүгийн мэдээллийн ил тод байдал хангагдсан эсэх				
5. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА	10 оноо	10	5	10%
5.1. ТУЗ нь компанийн эрсдэлийн удирдлагын бодлогыг баталсан эсэх				
5.2. Эрсдэлийн удирдлагын хороо байгуулагдсан эсэх				
5.3. Эрсдэлийн үнэлгээ, шинжилгээ тогтмол хийгддэг эсэх				
5.4. Эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө боловсруулагдсан эсэх				
5.5. Эрсдэлийн удирдлагын хэрэгжилтэд ТУЗ хяналт тавьдаг эсэх				
6. ХҮНИЙ НӨӨЦ БА ЦАЛИН УРАМШУУЛАЛ	10 оноо	10	5	10%
6.1. ТУЗ нь гүйцэтгэх удирдлагын томилгоог баталдаг эсэх				
6.2. Гүйцэтгэх удирдлагын гүйцэтгэлийг ТУЗ үнэлдэг эсэх				
6.3. Шагнал урамшууллын бодлого тодорхойлогдсон эсэх				
6.4. ТУЗ-ийн гишүүдийн цалин хөлс, урамшуулал ил тод байна эсэх				
6.5. Ажилтнуудын сургалт, хөгжлийн бодлого хэрэгжиж байна эсэх				
7. ЁС ЗҮЙ БА НИЙЦЭЛ	10 оноо	10	5	10%
7.1. ТУЗ нь компанийн ёс зүйн дүрмийг баталсан эсэх				
7.2. Ёс зүйн зөрчил гарсан тохиолдолд хариуцлага тооцох механизм бий эсэх				
7.3. Компанийн үйл ажиллагаа холбогдох хууль, дүрэм журамд нийцэж байгаа эсэх				
7.4. Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх бодлого хэрэгжиж байгаа эсэх				

7.5. Нийцлийн хяналтын алба эсвэл ажилтан томилогдсон эсэх				
8. МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ БА ХАРИЛЦАА	10 оноо	10	5	10%
8.1. ТУЗ нь хувьцаа эзэмшигчидтэй харилцах бодлого.				
8.2. ТУЗ нь хувьцаа эзэмшигчид болон бусад оролцогч талуудад шаардлагатай мэдээллийг тогтмол хүргэдэг эсэх				
8.3. Компанийн вэб сайт болон бусад сувгуудаар үйл ажиллагааны мэдээлэл ил тод нийтлэгддэг эсэх				
8.4. Жил бүрийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг нийтэд ил тод мэдээлдэг эсэх				
8.5. Олон нийтийн мэдээлэлд нээлттэй байх бодлого хэрэгжиж байгаа эсэх				
9. НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА БА ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ	10 оноо	10	5	10%
9.1. ТУЗ нь компанийн нийгмийн хариуцлагын бодлогыг баталсан эсэх				
9.2. Компанийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг ТУЗ хянаж, удирддаг эсэх				
9.3. Нийгмийн хариуцлагын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, хяналт тавьдаг эсэх				
9.4. Компанийн үйл ажиллагаа тогтвортой хөгжлийн зарчимд нийцэж байгаа эсэх				
9.5. Оролцогч талуудтай байгаль орчин, нийгмийн хариуцлагын асуудлаар зөвлөлдөж байгаа эсэх				
10. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ, ОРОЛЦОО	10 оноо	10	5	10%
10.1. ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах бодлогыг хэрэгжүүлж байгаа эсэх				
10.2. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг тогтмол зохион байгуулж, тэдний оролцоог хангаж байгаа эсэх				
10.3. Цөөнхийн хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа эсэх				
10.4. Хувьцаа эзэмшигчдэд саналаа өгөх эрхийг хангах механизмууд ажиллаж байгаа эсэх				
10.5. Нэмэлт хувьцаа гаргах, ногдол ашиг хуваарилах шийдвэрийг хувьцаа эзэмшигчидтэй зөвлөлдөж гаргадаг эсэх				
НЭГДСЭН ҮНЭЛГЭЭ (100 ХУВИАС)				

Хүснэгт 2. ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны үнэлгээний асуулт

		ХАРИУЛТ	ОНОО	ЖИН	ҮНЭЛГЭЭ
1. БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН		12 оноо	12	16	16%
1.1	Хороо нь ТУЗ-ийн хараат бус гишүүдээс бүрдсэн эсэх				
1.2	Гишүүдийн мэргэшлийн түвшин, туршлага				
1.3	Гишүүдийн тоо, хуралдах давтамж				
1.4	Дотоод аудиттай хэрхэн хамтран ажилладаг эсэх				
2. ХАРААТ БУС БАЙДАЛ		9 оноо	9	12	12%
2.1	Хорооны дарга хараат бус гишүүн эсэх				
2.2	Гишүүдийн хөндлөнгийн хараат бус байдал				

2.3	Аудитын компанитай холбоогүй эсэх				
3. ҮЙЛ АЖИЛЛАГАА		9 оноо	9	12	12%
3.1	Аудитын хороо тайлангаа ТУЗ-д тогтмол хүргэдэг эсэх				
3.2	Хяналтын бодлого, журмуудыг мөрдөж байгаа эсэх				
3.3	Дотоод болон гадаад аудитын үр дүнг хянах, санал дүгнэлт гаргах үйл явц				
4. АУДИТЫН ПРОЦЕСС		9 оноо	9	12	12%
4.1	Дотоод аудитын төлөвлөгөөтэй уялдсан байдал				
4.2	Гадаад аудитын хяналт-шинжилгээ хийх үүрэгтэй эсэх				
4.3	Аудитын тайлангуудын үнэлгээ, санал зөвлөмж гаргах байдал				
5. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА БА ДОТООД ХЯНАЛТ		9 оноо	9	12	12%
5.1	Эрсдэлийн удирдлагын системтэй хэрхэн уялдаж байгаа эсэх				
5.2	Санхүүгийн тайлагналын хяналт, дотоод хяналтын механизм				
5.3	Эрсдэлийн удирдлагын стратегийн хэрэгжилтэд аудитын хороо оролцдог эсэх				
6. ИЛ ТОД БАЙДАЛ, ТАЙЛАГНАЛ		9 оноо	9	12	12%
6.1	Хорооны үйл ажиллагааны ил тод байдал				
6.2	Гишүүдийн оролцооны тайлан				
6.3	Аудитын тайлангийн нийтийн хүртээл байдал				
7. ЁС ЗҮЙ, ХАРИУЦЛАГА		9 оноо	9	12	12%
7.1	Аудитын хорооны ёс зүйн дүрэмтэй эсэх				
7.2	Хараат бус байдлыг алдагдуулах үйлдлийг хориглох бодлого хэрэгжүүлж байгаа эсэх				
7.3	Ёс зүйн зөрчил гарсан тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээ				
8. ҮР ДҮН, БА ҮР НӨЛӨӨ		9 оноо	9	12	12%
8.1	Хорооны гаргасан шийдвэрийн хэрэгжилтийн хяналт				
8.2	Аудитын тайлан, зөвлөмжийн хэрэгжилт				
8.3	ТУЗ-ийн шийдвэр гаргахад нөлөөлж буй байдал				
НЭГДСЭН ҮНЭЛГЭЭ (100 ХУВИАС)					

Хүснэгт 3. ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны үнэлгээний асуулт

		ХАРИУЛТ	ОНОО	ЖИН	ҮНЭЛГЭЭ
ХОРООНЫ БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН		12 оноо	9	15	15%
1.1	Хороо нь ТУЗ-ийн хараат бус гишүүдээс бүрдсэн эсэх				
1.2	Гишүүдийн мэргэшлийн түвшин, туршлага хангалттай эсэх				
1.3	Гишүүдийн тоо, хуралдах давтамж зохистой эсэх				
2. ХАРААТ БУС БАЙДАЛ		12 оноо	9	15	15%
2.1	Хорооны гишүүд компанийн удирдлагаас хараат бус байх нөхцөл бүрдсэн эсэх				

2.2	Хараат бус гишүүдийн хувь нийт бүрэлдэхүүнд зохистой эсэх				
2.3	Нэр дэвшүүлэх үйл явцад аливаа ашиг сонирхлын зөрчилгүй оролцох боломжтой эсэх				
3. НЭР ДЭВШҮҮЛЭХ ҮЙЛ ЯВЦ		12 оноо	9	15	15%
3.1	Нэр дэвшүүлэх журам тодорхой, ил тод эсэх				
3.2	Гишүүдийг томилох болон чөлөөлөх бодлого үр нөлөөтэй эсэх				
3.3	Шинэ гишүүдийг сонгохдоо ур чадвар, туршлагыг гол шалгуур болгодог эсэх				
4. ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ		12 оноо	9	15	15%
4.1	Хороо нь ТУЗ-ийн бүрэлдэхүүний гүйцэтгэлийг тогтмол үнэлдэг эсэх				
4.2	Хорооны үйл ажиллагааны тайланг тогтмол гаргадаг эсэх				
4.3	Хорооны үйл ажиллагааны хэрэгжилтэд үнэлгээ хийдэг эсэх				
5. ИЛ ТОД БАЙДАЛ, ТАЙЛАГНАЛ		12 оноо	9	15	15%
5.1	Хорооны үйл ажиллагаа болон шийдвэр гаргах үйл явц ил тод эсэх				
5.2	Гишүүдийн томилгооны талаарх мэдээлэл олон нийтэд нээлттэй эсэх				
5.3	Хороо компанийн тайландаа үйл ажиллагааны талаар тусгадаг эсэх				
6. ЁС ЗҮЙ, ХАРИУЦЛАГА		6 оноо	6	10	10%
6.1	Хорооны үйл ажиллагаа болон шийдвэр гаргах үйл явц ил тод эсэх				
6.2	Гишүүдийн томилгооны талаарх мэдээлэл олон нийтэд нээлттэй эсэх				
7. ОЛОН УЛСЫН САЙН ТУРШЛАГА		12 оноо	9	15	15%
7.1	Хороо нь олон улсын компанийн засаглалын стандарт, зөвлөмжүүдийг дагаж мөрддөг эсэх				
7.2	Шилдэг туршлагыг судалж, үйл ажиллагаандаа тусгаж ажилладаг эсэх				
7.3	Нэр дэвшүүлэх процессыг тасралтгүй сайжруулах бодлого хэрэгжүүлдэг эсэх				
НЭГДСЭН ҮНЭЛГЭЭ (100 ХУВИАС)					

Хүснэгт 4. ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хорооны үнэлгээний асуулт

		ХАРИУЛТ	ОНОО	ЖИН	ҮНЭЛГЭЭ
ХОРООНЫ БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН		12 оноо	9	15	15%
1.1	Хороо нь ТУЗ-ийн хараат бус гишүүдээс бүрдсэн эсэх				
1.2	Гишүүдийн мэргэшлийн түвшин, туршлага хангалттай эсэх				
1.3	Гишүүдийн тоо, хуралдах давтамж зохистой эсэх				
2. ХАРААТ БУС БАЙДАЛ		12 оноо	9	15	15%
2.1	Хорооны гишүүд компанийн удирдлагаас хараат бус байх нөхцөл бүрдсэн эсэх				
2.2	Хараат бус гишүүдийн хувь нийт бүрэлдэхүүнд зохистой эсэх				

2.3	Цалин, урамшууллын шийдвэрт ашиг сонирхлын зөрчилгүй оролцох боломжтой эсэх				
3. ЦАЛИН, УРАМШУУЛЛЫН БОДЛОГО		12 оноо	9	15	15%
3.1	Цалин, урамшууллын бодлого компанийн стратегитай нийцэж буй эсэх				
3.2	Гүйцэтгэх удирдлагын цалин, урамшууллыг тогтоох тодорхой шалгуур байгаа эсэх				
3.3	Гүйцэтгэлд суурилсан урамшууллын тогтолцоо хэрэгждэг эсэх				
4. ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ		12 оноо	9	15	15%
4.1	Хороо нь гүйцэтгэх удирдлагын гүйцэтгэлийг тогтмол үнэлдэг эсэх				
4.2	Урамшууллын тогтолцоо компанийн зорилго, үнэт зүйлстэй нийцэж буй эсэх				
4.3	Гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнг цалин, урамшууллын бодлогод тусгадаг эсэх				
5. ИЛ ТОД БАЙДАЛ, ТАЙЛАГНАЛ		12 оноо	9	15	15%
5.1	Хорооны үйл ажиллагаа болон шийдвэр гаргах үйл явц ил тод эсэх				
5.2	Цалин, урамшууллын мэдээлэл олон нийтэд нээлттэй эсэх				
5.3	Цалин, урамшууллын талаар компанийн тайланд тогтмол мэдээлдэг эсэх				
6. ЭРСДЭЛ БА ХАРИУЦЛАГА		8 оноо	6	10	10%
6.1	Цалин, урамшууллын бодлого нь санхүүгийн эрсдэлийг бууруулах бодлоготой нийцдэг эсэх				
6.2	Урамшууллын бодлого компанийн урт хугацааны тогтвортой хөгжилд нийцэж буй эсэх				
7. ОЛОН УЛСЫН САЙН ТУРШЛАГА		12 оноо	9	15	15%
7.1	Хороо нь олон улсын компанийн засаглалын стандарт, зөвлөмжүүдийг дагаж мөрддөг эсэх				
7.2	Шилдэг туршлагыг судалж, үйл ажиллагаандаа тусгаж ажилладаг эсэх				
7.3	Цалин, урамшууллын бодлогыг тасралтгүй сайжруулах бодлого хэрэгжүүлдэг эсэх				
НЭГДСЭН ҮНЭЛГЭЭ (100 ХУВИАС)					